БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГА С.ЧУЛУУНШАГАЙ
20..3 оны ......р сарын......ний өдөр

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС БАЯН-ӨНДӨР СУМЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН АЖЛЫН ХЭСГИЙН
ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.

2023-04-26 "Бумбат

| Дэс | Баримт бичгүүдийн нэр | Зөвлөмжийн заалт | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан | Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан | Үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт** | | | | | | |
| 1. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эзэнжүүлж шаардлагатай шийдвэрт хувийн хэрэг нээж, хувийн хэргийн бүрдлийг ханган, баяжилтийг хийх<br>2.Өмнө нь гарсан шийдвэр, шийдвэрийн заалтыг шүүн үзэж цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасах, хэрэгжилт тогтмолжсон, байнгын шинжтэй шийдвэрүүдийг дотоод хяналтад авах<br>3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнаж байгаатай холбогдуулан хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа заалтуудыг үр дүнг нэмэгдүүлэх тал дээр санал санаачлага гарган хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай уялдаатай ажиллах<br>4.Хэрэгжилт тогтмолжсон, цаг | 1 дүгээр улиралд | Хууль эрх зүйн мэргэжилтэн | Албан байгууллагын дарга эрхлэгч нар,ТАХ-чид | Шинээр гарсан тогтоол шийдвэр болон хэрэгжиж байгаа шийдвэрүүдийн биелэлт тооцогдож эзэнжүүлсэн байна. Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон шийдвэрүүдийг хяналтаас хассан байна.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнасан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, нэг удаагийн шинжтэй заалтуудыг тухай бүр хяналтаас хасах<br>5.Аймгийн Засаг даргын 2022 оны Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллах | | | | |
| 2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | Хөтөлбөрийн заалт тус бүрээр эзэнжүүлж, хувийн хэрэг үүсгэн баяжилтийг хийх | 2 дугаар улиралд | Засаг даргын орлогч | Албан байгууллагын дарга эрхлэгч нар,ТАХ-чид | Хөтөлбөрүүдийг эзэнжүүлж, хувийн хэрэг хөтлөлтийн баяжилт хийгдсэн байна. |
| 3 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | Бодлогын баримт бичгийг тайлагнахдаа зорилтод түвшинийг тодорхойлж, төлөвлөлтийн чанарыг сайжруулж ажиллах | Хагас бүтэн жилд | Тамгын газрын дарга | Байгууллагын дарга эрхлэгч нар, ТАХ-чид | Бодлогын баримт бичгийн тайлан төлөвлөлтийн чанарыг сайжруулж ажилласан байна. |
| 4 | Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 1.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг суманд хэрэгжүүлж болох арга хэмжээг хяналтанд авч, жилийн эхнээс төлөвлөн хэрэгжүүлж ажиллах<br>2.Хэрэгжилтийг батлагдсан журмын дагуу товч тодорхой, иж бүрэн тайлагнан ажиллах | Жилдээ | Засаг даргын орлогч Тамгын газрын дарга | Албан байгууллагын дарга эрхлэгч нар, ТАХ-чид | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөгжлийн жилийн төлөвлөгөө тусгагдаж бүрэн хэрэгжсэн байна. |
| 5 | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж батлуулан хэрэгжүүлэх<br>2.Хэрэгжилтийг тайлагнахдаа зохион | Хагас бүтэн жилд | Засаг даргын орлогч Тамгын газрын дарга | Албан байгууллагын дарга эрхлэгч нар, ТАХ-чид | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлагналт өмнөх жилээс өссөн дүнгээр хүрэх үр дүн чанарт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, хэрэгжүүлсэн ажлаа бүрэн гүйцэт, ойлгомжтой тайлагнах<br>3.Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг суурь онтой харьцуулж, санхүүжилтийн эх үүсвэрийг дурдах | | | | суурилан гарсан байна. |
| **2.Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт** | | | | | | |
| 1 | Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт | 1.Гэрээний үүргийн биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу үнэлэх<br>2.Тус тусад нь тайлагнахаар оруулсан заалтуудыг тус тусад нь тайлагнах<br>3.Арга хэмжээний биелэлтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах | Хагас бүтэн жилд | Засаг даргын орлогч | Тамгын газрын дарга | Гэрээний үүргийн биелэлтийн тайлагналт өмнөх жилээс өссөн дүнгээр хүрэх үр дүн чанарт суурилан гарсан байна |
| 2 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт | 1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг албан хаагчдын саналыг тусгаж хуульд нийцүүлэн боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах<br>2.Хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд тодорхой тусгаж тайлагнах | Хагас бүтэн жилд | Тамгын газрын дарга | Байгууллагын дарга эрхлэгч нар | Хөтөлбөрийн төлөвлөгөөг албан хаагчдын саналыг тусган боловсруулж тайлагналтыг нэгтгэсэн байна |
| 3 | Төсөвт байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөөний хэрэгжилт | 1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заавал тусгах зорилт, зорилтын суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилт, зорилтот түвшинг тодорхойлох<br>2.Үг үсгийн алдаагүй, ойлгомжтой, хэтэрхий товч тайлагнахгүй байх, | Хагас бүтэн жилд | Тамгын газрын дарга | Байгууллагын дарга эрхлэгч нар | Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын тайлагналтыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшин нь хүрсэн түвшинтэйгээ уялдах<br>3.Тайлангийн чанарыг сайжруулж, нэгтгэх, дүгнэх ур чадварт албан хаагч бүрийг сургах, чадавхжуулах | | | | шалгуурт үзүүлэлт хүрсэн түвшинтэй нь уялдуулж тайлагнасан байна. |
| | 3.1 Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөөний хэрэгжилт | Зорилт бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжилтийг гаргаж үнэлгээ тавигдсан байхад анхаарах | | | | Зорилт бүр үр дүнтэй хэрэгжиж шалгуур үзүүлэлтэндээ хүрсэн байна. |
| | 3.2 Ерөнхий боловсролын сургуулийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөөний хэрэгжилт | 1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын чанартай, асуудал шийдвэрлэхэд чиглэсэн, тодорхой хөрөнгө шаардлагатай, орон нутгийн хэмжээнд тухайн салбарт баримталж байгаа бодлого чиглэлийг тусгаж, хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон байх<br>2.Шалгуур үзүүлэлт оновчтой байх, тайланг хэт нуршуу, үйл явц тайлагнасан байгаад анхаарах<br>3.Зарим арга хэмжээ, шалгуур үзүүлэлт болон биелэлт харилцан уялдаатай байх<br>4.Хэрэгжилтийг тайлагнаагүй тохиолдолд 0 хувиар дүгнэх<br>5.Маягтын дагуу зорилт бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжилтийг гаргаж үнэлгээ тавих | | | | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлагналт тодорхой бодит үр дүнд хүрсэн, хугацаандаа зорилт нэг бүрээр хэрэгжиж үнэлгээ дүгнэлтээ авсан байна. Үнэлгээ дүгнэлт 80-аас дээш үнэлэгдсэн байна. |
| | 3.3 Соёлын төв | 1.Үйл ажиллагааны чиглэл, зорилтоо салбарын бодлоготой уялдуулан тодорхойлж, түүний дагуу үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох<br>2.Хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүн, үр нөлөөг тодорхойлох, тайлангийн чанар, тайлагналтад сайтар анхаарах | | | | Үйл ажиллагааны төлөвлөлт салбар дундаа уялдсан хамтран хэрэгжүүлсэн үр нөлөө үр дүнг тодорхойлсон байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.4 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | 1.Суурь түвшин тодорхойлох аргачлалд суралцах<br>2.Тайлангийн чанарт анхаарах, тайлагналтыг үйл явцыг бус үр дүн, үр нөлөөг тооцож тайлагнах | | | | Тайлангийн бичилтийн чанарыг үйл явц бичихгүйгээр үр дүн, үр нөлөөг тооцож тодорхой тоо баримтан дээр үндэслэн бичигдсэн байна. |
| | 3.5 Эрүүл мэндийн төв | 1.Суурь түвшин болон зорилтод түвшин бүгд 100 хувиар төлөвлөгдсөн, шалгуур үзүүлэлтийг хүрэх үр дүн байдлаар томъёолсон алдааг засах<br>2.Зорилт бүрт арга хэмжээний агуулгыг багтаасан шалгуур үзүүлэлт, зорилтод түвшин тавигдсан, түүнийхээ хэрэгжилтийг тайлагнасан байх шаардлагыг анхаарах<br>3. Арга хэмжээ бүрийн хэрэгжилт, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаах | | | | Тайлангийн бичилтийн чанарыг үйл явц бичихгүйгээр үр дүн, үр нөлөөг тооцож тодорхой тоо баримтан дээр үндэслэн бичигдсэн байна. |
| 4 | Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хувийн хэвшлийг дэмжсэн байдал | 1.Хөрөнгийн чанар, ашиглалт, хадгалалтын чанарыг сайжруулах<br>2.Удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх<br>3.ОНХ-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулгад иргэдийг тэгш хүртээмжтэй оролцуулах, саналын хуудсыг хүртээмжтэй байдлаар тарааж, иргэдийг идэвхжүүлэхэд санаачлагатай ажиллах<br>4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын эрэмбэлсэн_ жагсаалтад иргэдийн өгсөн санал орсон эсэхийг иргэдэд бүрэн мэдээлж ажиллах<br>5.Дотоод аудит, хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Хагас бүтэн жилд | Засаг дарга, Тамгын газрын дарга | ИТХурал | ОНХСангийн хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг шилэн дансны цахим хуудсаар, цахимаар ирүүлсэн иргэдийн саналыг эрэмбэлж журмын дагуу хэрэгжүүлж графикт хугацаанд тайлагнасан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах | | | | |
| | | **3.Байгууллагын нээлттэй байдал** | | | | |
| 1 | Байгууллагын ил тод байдал | 1.Байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй мэдээлэхээр заасан мэдээллийн жагсаалтын дагуу хөтлөх, шинэчлэх ажлыг албан хаагчдад хариуцуулж, хяналт тавьж ажиллах<br>2.Мэдээллийн шинэчлэлтийн хугацаа, мэдээ, мэдээллийн агуулга, алдааг хянаж засварлах<br>3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу бүх төсөвт байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангаң ажиллах<br>4.Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийгдсэн ажлуудын нийт төсвийг тайлагнах | Улирал бүр | Тамгын газрын дарга | Байгууллагын дарга эрхлэгч нар | Байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийн тайлагналт үр дүнд суурилж тодорхой, статистик тоо баримтанд тулгуурлан өмнөх оны суурь түвшинг хүрсэн үр дүнтэй тайлагнасан, байна. |
| 2 | Шударга байдлын түвшин | 1.Төрийн байгууллагууд цахим сайтад байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол шинэчилж байх, мөн авлигын чиглэлээр өдөр тутмын хийсэн ажлуудаа тогтмол оруулах<br>2.Сумын Засаг даргаас төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт оруулах,<br>3.Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд сургалтын менежер, нягтлан бодогч нарын албан тушаалтнууд өөрчлөгдөх, солигдох, ажлаас чөлөөлөгдөх тухай бүр сумын | Улирал бүр | Тамгын газрын дарга | Байгууллагын дарга эрхлэгч нар | Шударга байдлын хэрэгжилтийн тайлан ил тод, үнэн зөв хуулийн хугацаанд мэдээлэгдсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Засаг даргын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэн, ХАСУМ хянуулах, томилогдсоны дараа 30 хоногт ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой заалт тусган, үр дүнг тооцож ажиллах | | | | |
| 3 | Шилэн дансны хөтлөлт | 1.Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах<br>2.Системийн ачаалыг тооцон 2 хоногийн өмнөөс тайланг илгээж хэвших<br>3.Санхүүгийн хяналт аудитын албанаас өгч буй зөвлөмж, албан шаардлагыг тухай бүр хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгаж ажиллах | Улирал бүр | Санхүү албаны дарга | Төсөвт байгууллагын нягтлан бодогч нар | Шинэ дансны хөтлөлт хугацаандаа үнэн зөв мэдээлэгдэж зөрчил дутагдалгүй ажилласан байна. |
| 4 | Хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмж | 1.Байгууллагын ёс зүйн зөвлөл болон дотоод хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарах<br>2.Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх<br>3.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичгийн стандарт (MNS 5140:2021)-ын хэрэгжилтийг хангаж ажиллах<br>4.Байгууллага бүр үйл ажиллагаандаа | жилдээ | Тамгын газрын дарга | Албан байгууллагын дарга, эрхлэгч нар | Хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөмжийг зорилтын биелэлтийг баримтжуулан ажиллаж бүртгэл хяналтанд тусгасан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зайлшгүй мөрдөгдөх дүрэм, журам (Албан хэрэг хөтлөлтийн журам, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам г.м) боловсруулж мөрдөх<br>5.Байгууллагын архивт албан хаагчдаас баримтыг бүрэн бүрдэлтэй, хугацаанд нь шилжүүлэн авч хэвших, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх<br>6.Хариутай албан бичигт хяналтын карт хөтлөх. Албан бичиг болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хөтлөлтийг бүртгэлийн дэвтэр болон хяналтын картанд тодорхой тусгаж, эргэн мэдэгдсэн байдал тодорхой байх асуудалд анхаарах | | | | |
| 5 | Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанар | 1.Журмын 11 дүгээр хавсралтын дагуу шалгуур үзүүлэлтийг тайлагнахдаа суурь түвшингээ тодорхойлон үр дүнг хүрэх түвшинтэйгээ харьцуулж шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэх | улирал, хагас бүтэн жилээр | Тамгын газрын дарга | Албан байгууллагын дарга эрхлэгч нар | Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлан хугацаандаа үнэн зөв мэдээлэгдсэн байна. |
| | Ногоон байгууламж | 1.Сумд мод тарих газрыг газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах<br>2.Тарьсан модны усалгаа, арчилгаа хэрхэн шийдэж авч явах тал дээр онцгой анхаарч жил бүр тарьсан модны тооллого зохион байгуулж амьдралтын хувийг үнэн зөв тодорхойлж байх | улирал, хагас бүтэн жилээр | Байгаль орчны хяналтын Улсын байцаагч | Албан байгууллагын дарга эрхлэгч нар | Мод тариалалт өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. |
| | Цахим шилжилт | 1.Төрийн цахим үйлчилгээний | улирал, хагас | Хур систем, | Албан | Цахим төрийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэглээг нэмэгдүүлэх, E-Mongolia системд нэвтрүүлсэн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах зохион байгуулалтын арга хэмжээ авч идэвх санаачлагатай ажиллах<br>2.Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем erp.e-mongolia.mn-ийг нэвтрүүлэх, ашиглалтыг эрчимжүүлэх<br>3.Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахад анхаарч ажиллах, төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан хаагчид Кебир аюулгүй байдлын болон бусад чиглэлээр зохион байгуулагдаж байгаа сургалтад хамрагдах | бүтэн жилээр | E-Mongoliaсистем хариуцсан мэргэжилтэн | байгууллагын дарга эрхлэгч нар | үйлчилгээнд иргэдийн 70-80 хувийг хамруулж мэдээллийн системд хамрагдсан байна.<br><br>Нууцын зэрэглэлтэй төрийн албан хаагчид сургалтанд хамрагдаж кебир аюулгүй байдлын мэдээлэл хийгдсэн байна. |
| | Хог хаягдлын менежмент | 1.Сумын төсөвт болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд эх үүсвэр дээр нь ангилан ялгах савыг нэг бүрчлэн байршуулах, ангилсан дахивар хог хаягдлыг аймаг, орон нутгийн дахивар хүлээн авах цэгүүдэд хүргэх горимыг тодорхой болгож тухайн үйл ажиллагааг тогтмолжуулах<br>2.Төвлөрсөн хогийн цэг дээр байгуулсан аюултай хог хаягдлыг устгах цэгт аюултай хог хаягдлыг Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу устгаж хэвших<br>3.Иргэд, хүүхэд багачуудад хог | улирал, хагас бүтэн жилээр | Байгаль орчны хяналтын Улсын байцаагч | Албан байгууллагын дарга эрхлэгч нар | Хог хаягдлыг ялган ангилж аюултай хог хаягдлын талаар мэдээ мэдээллийг өсвөр үеийнхэн, ард иргэдэд сурталчлан таниулж хэвшүүлсэн байна.Тайлангийн бичилтийн чанарыг үйл явц бичихгүйгээр үр дүн, үр нөлөөг тооцож тодорхой тоо баримтан дээр үндэслэн бичигдсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, иргэдийн зөв дадал хэвшилтэй холбоотой сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх | | | | |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.ЦЭРЭНСУГАР